



**МОНГОЛБАНК**  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

## **МӨНГӨ, САНХҮҮГИЙН СТАТИСТИК**

Танилцуулга  
2020 оны 9 дүгээр сар


Улаанбаатар  
2020



### 1 Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлт (M2 мөнгө) өмнөх оны мөн үеэс 9.8 хувиар өсч 22.4 их наяд төгрөгт хүрлээ. M2 мөнгөний жилийн өсөлтийн 10.7 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, 4.2 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 0.5 нэгж хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, -1.7 нэгж хувийг төгрөгийн харилцах, -4.0 нэгж хувийг гадаад валютын харилцах тус тус бүрдүүлж байна.

Зураг 1-1: M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 9.8%-иар нэмэгдсэн байна.



Эх сурвалж: Монголбанк

Өмнөх сартай харьцуулахад мөнгөний нийлүүлэлт 4.3 хувиар өсөхөд хувийн байгууллагын гадаад валютын хадгаламж, иргэдийн төгрөгийн хадгаламж, харилцах нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Зураг 1-2: M2 мөнгө өмнөх сараас 4.3 хувиар өсөв.




Эх сурвалж: Монголбанк

Нийт хадгаламжийн хэмжээ 16.8 их наяд төгрөг байгаагаас 83.2 хувь буюу 13.9 их наяд төгрөг нь иргэдийн, 16.8 хувь буюу 2.8 их наяд

төгрөг нь байгууллагын хадгаламж байна. Нийт хадгаламжийн 30.5 хувь нь гадаад валютын хадгаламж байна. Үүнээс иргэдийн хадгаламжийн 25.8 хувийг, байгууллагын хадгаламжийн 53.6 хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байна.


Зураг 1-3: Нийт хадгаламж өмнөх оны мөн үеэс 22.2%-иар өсчээ.



Эх сурвалж: Монголбанк

M2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл, Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр актив (ДЦА)-ын дүн 18.5 их наяд төгрөг, гадаад цэвэр актив (ГЦА)-ын дүн 3.9 их наяд төгрөгтэй тус тус тэнцэж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулсан M2 мөнгөний өсөлтийн 5.4 нэгж хувийг ГЦА, 4.4 нэгж хувийг ДЦА бүрдүүлж байна.

Зураг 1-4: M2 мөнгөний жилийн өсөлтийг ГЦА-ын өсөлт бүрдүүлж байна.




Эх сурвалж: Монголбанк

## 2 Банкуудын зээл

### 2.1 Зээлийн өсөлт

Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар буурч 17.2 их наяд төгрөгт хүрсэн байна. Үүнээс хувийн байгууллагын зээл 6.4 хувиар буурч 8.0 их наяд төгрөгт, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 5.6 хувиар буурч 8.8 их наяд төгрөгт хүрчээ.

Зураг 2-1: Нийт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар буурч 17.2 их наяд төгрөг болов.




Эх сурвалж: Монголбанк

Нийт зээлийн үлдэгдлийн 1.6 их наяд төгрөг буюу 9.3 хувь нь гадаад валютаар олгосон зээл байна.

### 2.2 Зээл олголт, эргэн төлөлт

Тайлант сард шинээр олгосон зээл өмнөх сараас 225.5 тэрбум төгрөгөөр, эргэн төлөгдсөн зээл 310.6 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ.

Зураг 2-2: Тайлант сард 1,819.1 тэрбум төгрөгийн зээл олгогдож, 1,859.3 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдлөө.




Эх сурвалж: Монголбанк

Шинээр олгосон зээлийн 8.3 хувь буюу 151.0 тэрбум төгрөгийг гадаад валютаар олгожээ.

### 2.3 Чанаргүй зээл

Чанаргүй зээлийн 74.5 хувийг, хугацаа хэтэрсэн зээлийн 82.9 хувийг хувийн байгууллагын зээл бүрдүүлж байна.

Зураг 2-3: Нийт зээлийн 11.4% нь чанаргүй зээл, 6.6% нь хугацаа хэтэрсэн зээл байна.



Тайлбар: \* үйл ажиллагаа явуулж буй 13 банкаар  
Эх сурвалж: Монголбанк

Чанаргүй зээлийн үлдэгдэл 1,964.0 тэрбум төгрөгт хүрч өмнөх сартай харьцуулахад 4.6 тэрбум төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээлийн 11.8 хувь нь гадаад валютын зээл байна.

Чанаргүй зээлийн 21.7 хувийг уул уурхай, 18.7 хувийг боловсруулах, 13.0 хувийг барилга, 10.2 хувийг үл хөдлөх, 7.2 хувийг худалдааны салбарын зээл тус тус эзэлж байна.

Зураг 2-4: Чанаргүй зээлийн 74.5% хувийн байгууллагын, 24.6 хувийг иргэдийн зээл байна.




Эх сурвалж: Монголбанк

2.4 Хувийн байгууллагын зээл

Хувийн байгууллагын зээлийн үлдэгдэл тайлант сард 111.2 тэрбум төгрөгөөр буурчээ.

Зураг 2-5: Хувийн байгууллагын зээлийн үлдэгдлийн дийлэнх хувийг худалдаа, барилга, боловсруулах болон уул уурхайн салбарын зээл бүрдүүлж байна.



Эх сурвалж: Монголбанк

Хувийн байгууллагын зээлийн үлдэгдлийн сарын өөрчлөлтийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилан харуулбал, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын зээл 9.8 тэрбум, уул уурхайн салбарын зээл 9.7 тэрбум төгрөгөөр тус тус өсч, барилгын салбарын зээл 48.0 тэрбум, худалдааны салбарын зээл 23.7 тэрбум, мэдээлэл холбооны салбарын зээл 21.1 тэрбум, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарын зээл 15.8 тэрбум, тээвэр агуулахын үйл ажиллагааны салбарын зээл 13.6 тэрбум төгрөгөөр тус тус буурээ.

Тайлант сард хувийн байгууллагад 740.7 тэрбум төгрөгийн зээл шинээр олгогдсоны 19.2 хувь буюу 142.3 тэрбум төгрөгтэй тэнцэх зээл гадаад валютаар олгогджээ.

Зураг 2-6: Тайлант сард худалдаа, уул уурхай, барилгын салбарт дийлэнх зээл олгогдсон байна.



\*Цахилгаан хий, усан хангамж, газар тариалан, мэдээлэл холбоо, санхүү даатгал, мэргэжлийн ШУ, захиргаа, төрийн удирдлага, боловсрол, эрүүл мэнд гэх мэт салбарууд.  
Эх сурвалж: Монголбанк

2.5 Иргэдийн зээл

Иргэдийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 108.2 тэрбум төгрөгөөр өсчээ.

Зураг 2-7: Иргэдийн зээлийн 42% (МИК-д шилжүүлсэн багцыг оруулснаар)-ийг орон сууцны зээл, 26%-ийг цалин тэтгэврийн зээл бүрдүүлэв.




Эх сурвалж: Монголбанк

Иргэдийн зээлийг задалж авч үзвэл, өмнөх сараас ипотекийн зээлийн үлдэгдэл 49.3 тэрбум (МИК-д шилжсэн багцыг оруулснаар), худалдааны салбарын зээлийн үлдэгдэл 8.9 тэрбум, хадгаламж барьцаалсан зээлийн үлдэгдэл 7.7 тэрбум төгрөгөөр тус тус өсч, цалин, тэтгэврийн зээлийн үлдэгдэл 9.8 тэрбум төгрөгөөр, автомашины зээлийн үлдэгдэл 7.4 тэрбум төгрөгөөр, картын зээлийн үлдэгдэл 3.5 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Тайлант сард иргэдэд 1003.3 тэрбум төгрөгийн зээл шинээр олгогдсоны 0.9 хувь нь гадаад валютаар олгогджээ.

Зураг 2-8: Иргэдийн зээлийн ихэнх хувийг хадгаламж барьцаалсан, цалин тэтгэвэр эзэлж байна.




\*ХАА, газар тариалан, боловсруулах, цахилгаан хий, усан хангамж, тээвэр агуулах, үйлчилгээ, мэдээлэл холбоо, мэргэжлийн ШУ, захиргаа, төрийн удирдлага, боловсрол, эрүүл мэнд гэх мэт салбарууд.  
Эх сурвалж: Монголбанк

### 3 Ипотекийн зээл

2020 оны 9 дүгээр сарын байдлаар 99,559 зээлдэгч нийт 4,835.6 тэрбум төгрөгийн ипотекийн зээлтэй байна. Үүнээс хөтөлбөрийн эх үүсвэрээр 73,597 зээлдэгч 3,555.8 тэрбум төгрөгийн зээл авчээ.


Зураг 3-1: Ипотекийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт 6.7%-д хүрэв.



Эх сурвалж: Монголбанк

Ипотекийн зээлийн үлдэгдлийн 73.6 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 22.0 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр, 4.4 хувь нь бусад эх үүсвэрээр олгосон зээл байна. Нийт ипотекийн зээлийн 17.0 хувь буюу 820.5 тэрбум төгрөгийн зээл орон нутагт ногдож байна. Орон нутгийн ипотекийн зээл<sup>1</sup>-ийн 74.9 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 22.4 хувь нь банкны өөрийн эх үүсвэрээр, 2.7 хувь нь бусад эх үүсвэрээр олгогджээ.


Зураг 3-2: Нийт зээлийн 17.0% буюу 820.5 тэрбум төгрөг орон нутагт ногдож байна.



Эх сурвалж: Монголбанк

Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 95.3 хувь нь хэвийн, 1.6 хувь нь хугацаа хэтэрсэн, 3.1 хувь нь чанаргүй зээл байна. Чанаргүй ангилалд шилжсэн ипотекийн зээлийн 49.6 хувийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 49.3 хувийг хөтөлбөрийн зээл, 1.1 хувийг бусад эх үүсвэрийн зээл эзэлж байна.

Зураг 3-3: Өмнөх сараас хугацаа хэтэрсэн зээл 13.2 тэрбум төгрөгөөр өсч, чанаргүй зээл 4.2 тэрбум төгрөгөөр буурчээ.



Эх сурвалж: Монголбанк

Тайлант сард 1,052 зээлдэгчид 77.3 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосон бөгөөд үүний 30.6 хувийг хөтөлбөрийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн байна.

<sup>1</sup> Уг зээл нь орон нутгийн банкны салбараас олгосон бус худалдан авсан орон сууцны байршлаар тооцсон.

Зураг 3-4: Тайлант сард шинээр 1,052 зээлдэгчид ипотекийн зээл шинээр олгожээ.



Эх сурвалж: Монголбанк

Тухайн сард шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.8 нэгж хувиар, өмнөх сараас 1.5 нэгж хувиар тус тус өсч 12.6 хувьд хүрсэн байна.

Зураг 3-5: Шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 12.6 хувьтай байна.




Эх сурвалж: Монголбанк

## 4 Хүү

### 4.1 Шинээр татсан хадгаламжийн хүү


2020 оны 9 дүгээр сард нийт шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 10.0 хувь, гадаад валютын хадгаламжийн ЖДХ 3.0 хувь байна. Төгрөгийн хадгаламжийн ЖДХ өмнөх оны мөн үеэс 1.1 нэгж хувиар буурчээ.

Зураг 4-1: Шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүү өмнөх сараас 1.1 нэгж хувиар буурчээ.



Эх сурвалж: Монголбанк

Зураг 4-2: Шинээр татсан хугацаатай хадгаламжийн хүү 10.6%, хугацаагүй хадгаламжийн хүү 6.4% байна.




Эх сурвалж: Монголбанк

### 4.2 Шинээр олгосон зээлийн хүү


Тайлант сард нийт шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 16.4 хувь, гадаад валютын зээлийн ЖДХ 11.0 хувь болж, шинээр олгосон төгрөгийн зээл өмнөх оны мөн үеэс 0.5 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 4-3: Шинээр олгосон төгрөгийн зээлийн хүү 16.4% байна.



Эх сурвалж: Монголбанк

Зураг 4-4: Шинээр олгосон нийт зээлийн хүү өмнөх оноос 0.5 нэгж хувиар буурав.




Эх сурвалж: Монголбанк

Иргэдэд 1,003.3 тэрбум төгрөгийн зээл олгосноос тал нь буюу 68.3 хувь нь 2 жил хүртэлх хугацаатай байна.

### 4.3 Үлдэгдлээр хадгаламжийн хүү

Нийт төгрөгийн хадгаламжийн үлдэгдэлд ЖДХ 10.8 хувьтай байна. Харин нийт гадаад валютын хадгаламжийн ЖДХ 3.8 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.2 нэгж хувиар буурав.

Зураг 4-5: Үлдэгдлээр жигнэсэн төгрөгийн хадгаламжийн хүү 10.8% байна.




Эх сурвалж: Монголбанк

Хадгаламжийн үлдэгдэлд ЖДХ иргэдийн төгрөгийн хадгаламжийн хувьд 11.0 хувь, гадаад валютын хадгаламжийн хувьд 4.4 хувьтай байгаа бол хувийн байгууллагын төгрөгийн хадгаламжийн хувьд 9.5 хувьтай байна.

### 4.4 Хүүний зөрүү

Тухайн сард шинээр олгосон төгрөгийн зээл болон тухайн сард шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүүний зөрүү 2020 оны 9 дүгээр сарын байдлаар 6.5 нэгж хувьд хүрэв.

Зураг 4-6: Хадгаламж, зээлийн хүүний зөрүү өмнөх оноос 0.6 нэгж хувиар өсчээ.




Эх сурвалж: Монголбанк

### 4.5 Зээлийн үлдэгдлээр хүү

Төгрөгийн зээлийн үлдэгдэлд ЖДХ 16.9 хувь, гадаад валютын зээлийн ЖДХ 10.5 хувьтай байна. Үүнээс иргэдийн төгрөгийн зээлийн үлдэгдлийн ЖДХ 17.9<sup>2</sup> хувьтай, гадаад валютын зээлийн ЖДХ 12.2 хувьтай байна. Хувийн байгууллагын зээлийн ЖДХ 15.6 хувьтай, гадаад валютын зээлийн хүү 10.4 хувьтай байна.


Зураг 4-7: Иргэдийн зээлийн үлдэгдлийн хүү өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар өсчээ.



Эх сурвалж: Монголбанк

Зээлийн үлдэгдлийн дийлэнхийг 2-5 жилийн хооронд төлөгдөж дуусах зээлүүд эзэлж байна.

Зураг 4-8: Зээлийн үлдэгдэл, хугацаагаар



Эх сурвалж: Монголбанк

<sup>2</sup> Хөтөлбөрийн зээлийн дүнгүүдийг оруулаагүй болно.


## 5 Инфляц

### 5.1 Улсын инфляц

Хэрэглээний үнийн улсын индекс 2020 оны 9 дүгээр сарын байдлаар жилийн 1.7 хувь, сарын инфляц -0.3 хувь байна.

Жилийн инфляцыг авч үзвэл хүнсний барааны үнийн өсөлт нь хүнсний ногооны үнийн өсөлтөөр тодорхойлогдож байгаа бол хүнснээс бусад барааны өсөлтөд хувцас, бөс бараа болон боловсролын үйлчилгээний бүлгийн үнийн өсөлт нөлөөлсөн байна. Харин тээврийн бүлгийн үнэ буурсан хэвээр байна.

Зураг 5-1: Улсын жилийн инфляц 1.7 хувьтай байна.




Эх сурвалж: УСХ

### 5.2 Улаанбаатар хотын жилийн инфляц

Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс 9 дүгээр сарын байдлаар 1.4 хувь байгаа ба 1.2 нэгж хувийг хүнснээс бусад бараа, 0.2 нэгж хувийг хүнсний барааны үнийн өсөлт бүрдүүлж байна.

Зураг 5-2: УБ хотын жилийн инфляц 1.4 хувьд хүрэв.



Эх сурвалж: УСХ


Хүнсний барааны бүлгийн үнэд сүү, сүүн бүтээгдэхүүн болон жимс, жисгэний үнийн өсөлт, хүнснээс бусад барааны үнэд хувцас, бөс бараа гутлын бүлгийн үнийн өсөлт

нөлөөлжээ. Харин мах, махан бүтээгдэхүүн болон хүнсний ногоо, тээврийн бүлгийн үнэ буурсан байна.

### 5.3 Улаанбаатар хотын сарын инфляц

Өмнөх сартай харьцуулахад УБ хотын хэмжээнд инфляц -0.3 хувьтай байна. Үүний -0.7 нэгж хувийг хүнсний бараа, 0.4 нэгж хувийг хүнснээс бусад барааны үнийн өсөлтөөр тайлбарлагдаж байна. Хүнсний барааны үнэ буурсан нь хүнсний ногоо болон мах махан бүтээгдэхүүний үнийн бууралттай холбоотой байна. Харин хүнснээс бусад барааны үнийн өсөлтөд орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлэг, тээврийн бүлгийн үнийн өсөлт нөлөөлжээ.

Зураг 5-3: УБ хотын сарын инфляц -0.3 хувь.



Эх сурвалж: УСХ




## 6 Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш

### 6.1 Ам.долларын ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш сарын эцсийн байдлаар 2,854.72 төгрөгт хүрсэн нь өмнөх сарын эцсээс 0.1 хувиар, өмнөх оны мөн үеэс 7.0 хувиар суларсан үзүүлэлт байна. Тайлант сарын дундаж ханш нь 2,854.17 төгрөг байв.

Зураг 6-1: Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өөрчлөлт.

жилийн өсөлт %




Эх сурвалж: Монголбанк

### 6.2 Хятадын юанийн ханш

Төгрөгийн юаньтай харьцах сарын эцсийн ханш өмнөх сараас 0.8 хувиар суларч 419.28 төгрөгт хүрэв. Тухайн сарын хамгийн бага ханш нь 416.83 төгрөг байсан бол хамгийн өндөр ханш нь 422.24 төгрөг байлаа.

Зураг 6-2: Төгрөгийн юаньтай харьцах ханшийн өөрчлөлт.

жилийн өсөлт %



Эх сурвалж: Монголбанк